



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

Сургалтын хяналтын тоо, зардал
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг, "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 491/A472 дугаар хамтарсан тушаал, "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2014 оны 119 дүгээр тушаал, "Төгсөлтийн дараахь гадаад сургалтын тэргүүлэх чиглэл батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/169 дүгээр тушаал, "Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2017-2018 оны хичээлийн жилд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь үндсэн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоог нэгдүгээр, 2017-2018 оны хичээлийн жилд төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоог хоёрдугаар, 2017-2018 оны хичээлийн жилд сувилахуй, дүрс оношилгоо ба эмчилгээний тоног төхөөрөмжийн технологи, лабораторийн технологи, засвар үйлчилгээ, сэргээн заслын төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоог гуравдугаар, төгсөлтийн дараахь сургалтын 2017 оны зардлын төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар хавсралтаар тус тус батлагдсан хяналтын тоо, улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тооны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын холбогдох элсэлтийн хяналтын тоо, санхүүжилтийг хуваарилан, гэрээ байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

080674

3. Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хамтран зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль /Г.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалаар батлагдсан сургалтын чиглэл, индексийн дагуу ерөнхий мэргэшил судлалын сургалтын хөтөлбөрийг 2017 оны 2 дугаар улиралд, бусад чиглэлийн үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг 2017 оны 4 дүгээр улиралд, төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан шинээр болон шинэчлэн боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулан, сургалтыг шинээр болон шинэчлэн батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн ажилтныг гадаад сургалтад хамруулахтай холбоотой нийт гэрээг шинээр болон шинэчлэн боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д, эрүүл мэндийн ажилтныг улсын төсвийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь гадаад сургалтад хамруулахад баримтлах зарчим, тэргүүлэх чиглэлийн дагуу гадаад сургалтыг хамтран зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

6. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн яамны 2017, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан эрүүл мэндийн ажилтны багц цагийн сургалтын чиглэл, төлөвлөгөөг боловсруулж, Төрийн захиргааны удирдлагын газраар хянуулсны дараа баталж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

7. Төгсөлтийн дараахь сургалтын зардлын задаргааг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөрт багтаан баталж Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д даалгасугай.

8. Энэхүү тушаалаар батлагдсан төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын хяналтын тоог мөрдөж, ажиллахыг төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагын дарга/захирал нарт, батлагдсан мэргэшлийн чиглэл, хяналтын тооны дагуу шалгуур хангасан эмнэлгийн мэргэжилтэнг хамруулахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт тус тус үүрэг болгосугай.

9. Эрүүл мэндийн ажилтны 2016-2017, 2017-2018 оны төгсөлтийн дараахь сургалтын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт хийж, Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороогоор 2018 оны гуравдугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/, Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

10. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 02 сарын 12-ны өдрийн
А/ дугаар тушаалын 1 дүгээр
1988 хаворалт



2017-2018 оны хичээлийн жилд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн
дараахь үндсэн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн
санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоо

№	Сургалтын чиглэл	Хяналтын тоо		Үүнээс улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцуулах тоо	
		Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд	Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд
Нэг. Нүүр ам судлал					
1.	Нүүр амны гажиг судлал	16	16	0	0
2.	Нүүр амны мэс засал судлал	25	25	5	5
3.	Нүүр амны согог засал судлал	15	15	1	1
Хоёр. Анагаах ухаан					
4.	Анатомын эмгэг судлал	15	5	6	1
5.	Арьс судлал	25	15	7	1
6.	Гэмтэл согог судлал	30	15	7	1
7.	Дотрын анагаах судлал	125	50	31	6
8.	Дүрс оношлогоо судлал	55	25	11	2
9.	Ерөнхий мэргэшил судлал	32	32	32	32
10.	Зоонозын өвчин судлал	13	0	3	0
11.	Мэдрэл судлал	34	14	9	2
12.	Мэдээгүйжүүлэг судлал	32	12	11	2
13.	Мэс засал судлал	51	22	13	3
14.	Нүд судлал	31	11	9	2
15.	Өрхийн анагаах судлал	25	25	8	8

16.	Сүрьеэ судлал	15	0	8	0
17.	Сэтгэцийн өвчин судлал	17	7	5	1
18.	Хавдар судлал	21	6	5	1
19.	Халдварт өвчин судлал	22	7	10	2
20.	Хүүхэд судлал	40	20	35	7
21.	Чих, хамар, хоолой судлал	17	10	7	1
22.	Эмнэл зүйн эмгэг судлал	25	15	4	1
23.	Эрчимт эмчилгээ судлал	25	5	6	1
24.	Эх барих, эмэгтэйчүүд судлал	65	25	28	6
25.	Яаралтай тусламж судлал	17	3	17	3
Гурав. Сэргээн засал					
26.	Сэргээн засал судлал	11	5	5	1
Дөрөв. Уламжлалт анагаах ухаан					
27.	Зүү эмчилгээ судлал	39	15	4	1
28.	Монголын уламжлалт анагаах ухаан судлал	11	3	2	0
Нийт дүн		849	403	289	91

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 10-ны өдрийн
А/188 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

2017-2018 оны хичээлийн жилд төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлээр
суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн
санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоо

№	Сургалтын чиглэл	Хяналтын тоо		Үүнээс улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцуулах тоо	
		Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд	Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд
Нэг. Анатомийн эмгэг судлал					
1.	Эсийн эмгэг судлал	15	5	2	0
2.	Шүүхийн анагаах судлал	5	5	0	0
Хоёр. Арьс судлал					
3.	Эмчилгээний гоо засал, арьсны мэс засал судлал	3	3	0	0
Гурав. Гэмтэл согог судлал					
4.	Гар сарвууны нөхөн сэргээх бичил мэс засал судлал	6	3	2	0
5.	Доод мөчний нөхөн сэргээх бичил мэс засал судлал	6	3	0	0
6.	Нурууны мэс засал	5	2	0	0
7.	Түлэнхий, хөлдөлт судлал	6	2	6	1
8.	Үе бүтээх, солих мэс засал	2	2	0	0
9.	Хавсарсан гэмтлийн мэс засал судлал	3	3	1	0
10.	Хүүхдийн гэмтэл согог судлал	6	3	2	0
Дөрөв. Дотрын анагаах судлал					
11.	Бөөр судлал	17	5	8	2
12.	Дотоод шүүрэл судлал	10	8	4	1

13.	Зүрх судлал	20	8	2	0
14.	Настан судлал	10	5	6	1
15.	Ревматологи	5	3	1	0
16.	Уушиг судлал	13	5	4	1
17.	Хоол боловсруулах тогтолцоо судлал	20	8	6	1
18.	Хөнгөвчлөх эмчилгээ судлал	8	8	3	1
19.	Цус судлал	5	3	3	1
20.	Эмнэл зүйн хоол эмчилгээ судлал	15	0	2	1
21.	Эмнэл зүйн хордлого судлал	15	0	2	0
22.	Эмнэл зүйн эм судлал	10	10	0	0
Тав. Дүрс оношилгоо судлал					
23.	Ангиограф/ судасны дотуурх оношилгоо, эмчилгээ судлал	21	5	9	2
24.	Компьютер томограф/ соронзон давтамжит дүрс оношилгоо судлал	18	10	7	1
Зургаа. Мэдрэл судлал					
25.	Харвалт, тархины судасны эмгэг судлал	8	0	3	1
26.	Хүүхдийн мэдрэл судлал	11	5	4	1
Долоо. Мэдээгүйжүүлэг судлал					
27.	Хүүхдийн мэдээгүйжүүлэг судлал	9	3	4	1
Найм. Мэс засал судлал					
28.	Бөөрний мэс засал судлал	6	5	2	0
29.	Бүдүүн, шулуун гэдэсний мэс засал судлал	3	0	1	0
30.	Дотоод шүүрлийн мэс засал судлал	5	3	0	0
31.	Зүрх, судасны мэс засал судлал	6	0	1	0
32.	Мэдрэлийн мэс засал судлал	11	3	1	0
33.	Толгой, хүзүүний мэс засал судлал	9	5	2	0

34.	Хүүхдийн мэс засал судлал	9	3	3	1
35.	Хэвлийн мэс засал судлал	2	0	1	0
36.	Цээжний мэс засал судлал	2	0	2	0
37.	Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал судлал	6	0	2	0
Ес. Нүд судлал					
38.	Хүүхдийн нүд судлал	5	3	2	0
Арав. Сэтгэц судлал					
39.	Донтолт судлал	15	5	0	0
40.	Сэтгэл засал судлал	15	5	0	0
41.	Шүүхийн сэтгэц судлал	10	0	0	0
Арван нэг. Хавдар судлал					
42.	Хавдрын туяа эмчилгээ	8	3	0	0
43.	Хавдрын хими эмчилгээ	8	3	0	0
Арван хоёр. Халдварт өвчин судлал					
44.	Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирус/Дархлалын олдмол хомсдол судлал	10	10	4	1
45.	Талбарын тархвар судлал	7	0	0	0
46.	Хүүхдийн халдварт өвчин судлал	2	0	2	0
Арван гурав. Хүүхэд судлал					
47.	Нярай, перинатал судлал	15	5	10	2
48.	Өсвөр үе судлал	3	0	2	0
49.	Хүүхдийн бөөр судлал	9	5	2	1
50.	Хүүхдийн дотоод шүүрэл судлал	7	5	0	0
51.	Хүүхдийн зүрх судлал	9	5	1	0
52.	Хүүхдийн мэдрэлийн хөгжлийн эмгэг судлал	6	0	1	0
53.	Хүүхдийн ревматологи	2	0	0	0

54.	Хүүхдийн уушиг судлал	8	5	3	1
55.	Хүүхдийн хоол боловсруулах тогтолцоо судлал	7	5	1	0
56.	Хүүхдийн цус, хавдар судлал	7	5	0	0
Арван дөрөв. Чих, хамар, хоолой судлал					
57.	Хүүхдийн чих, хамар, хоолой судлал	3	3	2	0
Арван тав.Эмнэл зүйн эмгэг судлал					
58.	Эмнэл зүйн бичил амь судлал	20	5	4	1
59.	Эмнэл зүйн дархлаа, харшил судлал	8	8	3	1
60.	Эмнэл зүйн удам зүй судлал	3	3	0	0
61.	Эмнэл зүйн хими судлал	3	3	0	0
62.	Эмнэл зүйн цус судлал	3	3	0	0
63.	Эмнэл зүйн цус сэлбэлт судлал	18	3	3	1
Арван зургаа. Эрчимт эмчилгээ судлал					
64.	Хүүхдийн эрчимт эмчилгээ судлал	7	3	7	1
Арван долоо. Эх барих, эмэгтэйчүүд судлал					
65.	Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал	6	3	3	1
66.	Эмэгтэйчүүдийн хавдар судлал	8	3	4	1
67.	Эх ураг судлал	16	0	2	0
Арван найм. Яаралтай тусламж судлал					
68.	Хүүхдийн яаралтай тусламж судлал	3	3	2	0
Арван ес. Анагаах ухааны оношилгоо ба эмчилгээний технологи					
69.	Анагаахын бичил амь судлал	5	5	0	0
70.	Анагаахын дархлаа, харшил судлал	5	5	2	0
71.	Анагаахын молекул биологи судлал	5	5	0	0
72.	Анагаахын удам зүй судлал	5	5	0	0
73.	Цус судлал	5	5	0	0
74.	Цус, цусан бүтээгдэхүүний	5	5	0	0

	үйлдвэрлэлийн технологи				
75.	Эс судлал	5	5	0	0
Хорь. Эм зүй					
76.	Эмийн технологи судлал	8	8	0	0
77.	Эмийн шинжилгээ судлал	8	8	0	0
78.	Эмнэл зүйн эм зүй	13	13	3	1
Хорин нэг. Монголын уламжлалт анагаах ухаан судлал					
79.	Монголын уламжлалт анагаах ухааны дотор судлал	6	0	2	0
80.	Монголын уламжлалт анагаах ухааны засал судлал	6	0	2	0
Хорин хоёр. Нийгмийн эрүүл мэнд судлал					
81.	Биостатистик, тархвар зүй	23	8	8	2
82.	Орчны эрүүл мэнд судлал	20	5	2	0
83.	Хор судлал	15	0	1	0
84.	Хөдөлмөрийн эрүүл мэнд судлал	5	5	0	0
85.	Хүнсний эрүүл ахуй судлал	5	5	0	0
86.	Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт	10	10	0	0
Нийт дүн		736	337	174	31

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 12-ны өдрийн
А...дугаар тушаалын 3 дугаар
188 хавсралт



2017-2018 оны хичээлийн жилд сувилахуй, дүрс оношилгоо
ба эмчилгээний тоног төхөөрөмжийн технологи, лабораторийн
технологи, сэргээн заслын төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлээр
суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн санхүүжилтээр
тэтгэлэгтэй суралцагчдын тоо

№	Сургалтын чиглэл	Хяналтын тоо		Үүнээс улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцуулах тоо	
		Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд	Нийт тоо	Үүнээс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд
1. Сувилахуй					
1.	Арьсны сувилахуй	10	0	3	1
2.	Гэмтэл согог заслын сувилахуй	10	0	9	2
3.	Дархлаажуулалтын сувилахуй	50	15	33	7
4.	Монголын уламжлалт анагаах ухааны бариа заслын сувилахуй	25	10	11	2
5.	Монголын уламжлалт анагаах ухааны дотрын сувилахуй	5	0	3	1
6.	Мэдрэлийн сувилахуй	20	5	12	2
7.	Мэдээгүйжүүлгийн сувилахуй	35	20	13	3
8.	Мэс заслын сувилахуй	60	20	20	4
9.	Нүдний сувилахуй	15	10	1	0
10.	Нүүр амны сувилахуй	16	6	10	2
11.	Нярайн сувилахуй	45	10	35	7
12.	Өрхийн сувилахуй	45	15	4	1
13.	Сэргээн засахын сувилахуй	35	15	18	4

14.	Сэтгэцийн эмгэгийн сувилахуй	20	5	13	3
15.	Халдварт өвчний сувилахуй	15	0	10	2
16.	Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй	16	6	8	2
17.	Хүүхдийн сувилахуй судлал	43	8	33	7
18.	Цус, хавдрын сувилахуй	5	0	4	1
19.	Чих, хамар, хоолойн сувилахуй	15	5	7	1
20.	Эрчимт эмчилгээний сувилахуй	40	15	23	5
21.	Эх, хүүхдийн сувилахуй	25	10	5	1
22.	Яаралтай тусламжийн сувилахуй	70	30	37	7
2. Сэргээн засал судлал					
23.	Мэдрэлийн хөдөлгөөн засал судлал	5	0	3	1
3. Лабораторийн технологи					
24.	Бичил амь судлалын лабораторийн техникчийн сургалт	20	10	7	1
25.	Клиник биохими судлалын лабораторийн техникчийн сургалт	30	10	16	3
26.	Серологи судлалын лабораторийн техникчийн сургалт	15	10	4	1
27.	Эд судлалын лабораторийн техникчийн сургалт	9	4	2	0
28.	Эс судлалын лабораторийн техникчийн сургалт	9	4	4	1
4. Дүрс оношилгоо ба эмчилгээний тоног төхөөрөмжийн технологи, засвар үйлчилгээ					
29.	Компьютер томограф/рентген туяаны техникчийн сургалт	11	6	3	1
30.	Соронзон давтамжит дүрс оношлогооны техникчийн сургалт	9	6	1	0

5. Бусад					
31.	Ариутгагчийн сургалт	75	40	16	3
32.	Эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн ажилтны сургалт	55	30	23	5
Нийт дүн		858	325	391	81

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 12-ны өдрийн
А/... дугаар тушаалын 4 дүгээр
188 хавсралт



Төгсөлтийн дараахь сургалтын 2017 оны зардлын төсөв

№	Сургалтын төрөл	Суралцагчдын тоо	Төсөвлөсөн зардал (төгрөг)
1. Үндсэн мэргэшлийн сургалт			
1.	2014-2015 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл	3	1.536.000
2.	2014-2015 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл	3	14.400.000
3.	2015-2016 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл	184	129.536.000
4.	2015-2016 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл	184	446.100.000
5.	2016-2017 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл	199	140.096.000
6.	2016-2017 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл	199	656.700.000
7.	2017-2018 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтын зардал	289	55.488.000
2. Төрөлжсөн мэргэшлийн сургалт			
8.	2016-2017 оны хичээлийн жилийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл (их эмч)	90	35.264.000
9.	2016-2017 оны хичээлийн жилийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын тэтгэлгийн үргэлжлэл (их эмч)	90	124.800.000
10.	2017-2018 оны хичээлийн жилийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардал (их эмч)	174	33.408.000
11.	2016-2017 оны хичээлийн жилийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардлын үргэлжлэл (сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн)	192	18.432.000
12.	2017-2018 оны хичээлийн жилийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын зардал (сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн)	391	75.904.000

3. Мэргэжил дээшлүүлэх сургалт			
13.	2016-2017 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын үргэлжлэл (их эмч)	53	5.184.000
14.	2016-2017 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тэтгэлгийн үргэлжлэл (их эмч)	14	8.100.000
15.	2017-2018 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал (их эмч)	89	16.896.000
16.	2017-2018 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал (сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн)	143	11.360.000
4.Багц цагийн сургалт			
17.	2017-2018 оны хичээлийн жилийн ажлын байрны сургалт		310.417.506
18.	2017-2018 оны хичээлийн жилийн зайн сургалт	5000	9.500.000
5. Бусад			
19.	2017-2018 оны хичээлийн жилийн эрүүл мэндийн ажилтны гадаад сургалт	-	515.981.994
20.	Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	-	5.000.000
Нийт зардал			2.614.103.500